



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/243

Есөнбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх заалт, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэг Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийг дэмжих хөтөлбөр" боловсруулах, зөвлөгөөн зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

(Нийгмийн салбарын төслийн удирдагч)

Гишүүд:

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

(Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга)

(Аймгийн Боловсролын газрын дарга)

(Аймгийн Цагдаагийн газрын дарга)

(Аймгийн Цахим шилжилт, үйлчилгээний хэлтсийн дарга)

(Насан туршийн суралцахуйн төвийн захирал)

(Сумдын Засаг дарга нар)

(Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус холбоодын дарга нар)

Нарийн бичгийн дарга: Р.Наранбаатар

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын эрүүл мэнд, спорт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийг дэмжих хөтөлбөр боловсруулах

D:zahiramjZax ZD 2026

8200980408

ажлын нэгдсэн төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Э.Энхнаранд/ үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ